

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн халамжийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1.4-т “Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.”, 3.1.5-д “Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.”, “Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.”, “Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэж тусгасан.

Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-д Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар заасан.

Өнөөдрийн байдлаар Нийгмийн халамжийн чиглэлийн 6 хуулийн хүрээнд эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд Нийгмийн халамжийн сангаас 12 төрлийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Нийгмийн халамжийн сангаас 2025 онд нийт **2.4 их наяд** төгрөг зарцуулснаас нийт зардлын **27.8 хувь** нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг зэрэг нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд олгох зарцуулжээ. Харин **1 их наяд 745.8 тэрбум** төгрөг буюу нийт зардлын **70 гаруй хувийг** хүүхдийн мөнгөн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, одонтой эх, насны хишиг, жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг хөтөлбөрт зарцуулжээ.

Нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 2025 онд 2.7 байна. Харин хөгжиж буй орнуудын тухайд 1.6¹ хувийг эзэлдэг. Монгол Улсын хувьд нийгмийн халамжийн зардал эдийн засгийн хувьд ойролцоо улсуудтай харьцуулахад өндөр байна. Монгол Улсын ядуурлын түвшин ҮСХ-ноос мэдээлснээр 2022 онд 27.1 хувьтай байна. Хөдөөгийн хүн амын дунд ядуурлын түвшин илүү өндөр буюу 35.5 хувь байна.²

Судалгаанаас харахад нийгмийн халамжийн нийт зардлын 55 орчим хувь нь хүн амын хамгийн бага амьжиргаатай 40 хувьд, харин 26 хувь нь хүн амын хамгийн амьжиргаа сайтай 40 хувьд зарцуулагдсан байна. Энэ нь дийлэнх зардал нийтлэг мөнгөн тэтгэмжид зарцуулагдаж байгаатай холбоотой. Иймээс эх, хүүхдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийг халамжаас зааглан ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ анхдагч хуулийн төслийг боловсруулсан.

¹ “Монгол улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд: Үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан, 2015 он, Жунко Ониши, Чулууны Тунгалаг, Дэлхийн Банкны Групп

² Ядуурлын тооцооны арга зүйн өөрчлөлт, үр дүн 2022, ҮСХ, Дэлхийн банк, 2025 он.

Харин Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлж, халамжийг нэн шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн тэгш байдлыг хангах, салбар хоорондын уялдааг сайжруулахад анхаарлаа.

Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусгав. Үүнд:

1. Ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэдийг зөв тодорхойлох нь тулгамдсан асуудал болоод байна. Энэ хүрээнд өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг боловсронгуй болгох, төрийн мэдээллийн систем, их өгөгдөлд суурилах, мэдээллийг ядуурлыг бууруулах салбар дундын бодлого, хөтөлбөрт ашиглах асуудлыг тусгалаа.
2. 2025 оны тайлангаас харахад нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд зарцуулж байгаа 673.6 тэрбум төгрөгөөс 510.0 тэрбум төгрөг буюу зардлын 76 орчим хувийг зөвхөн аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч нарын тодорхойлолтод үндэслэн олгож байна.
Гэсэн хэдий ч халамжийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй болон асаргаа шаардлагатай иргэдийн хэрэгцээнд нийцсэн дутмаг байна.
Иймд асаргаа шаардлагатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие даан амьдрах чадамж, хэрэгцээний цогц үнэлгээг хийх Мэргэжлийн хамтарсан зөвлөлийг аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн байгууллагын дэргэд одоогийн бүтцийн хүрээнд ажиллуулахаар тогтолцооны шинэчлэлийг төсөлд тусгасан.
Энэ зөвлөл нь хараат бус, авлига ашиг сонирхлоос ангид байх, цахим системд суурилан санамсаргүй сонголтын аргаар зорилтот иргэдийг зөв тодорхойлно. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд суурилсан оновчтой, олон талт үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх юм.
3. Одоогийн халамжийн арга хэмжээнд бэлэн мөнгөний хөтөлбөрүүд халамжийн сангийн нийт зардлын 90.0 гаруй хувийг эзэлж байна. Улс орнуудын нийгмийн халамжийн тогтолцоонд бэлэн мөнгө олгохоос гадна чадавхжуулах, хөгжүүлэх, дэмжин туслах үйлчилгээ давамгайлдаг. Харин манай улсад хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж байгаа үйлчилгээнд халамжийн зардлын нэг хүрэхгүй хувийг зарцуулж байна.
 - Иймд хуулийн төсөлд зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн зан үйл, хандлагыг өөрчлөх, сургах, хөдөлмөрт бэлтгэх, аажмаар ядуурлаас гарган бие даан амьдруулахад чиглэсэн үйлчилгээг шинээр тусгасан;
 - Мөн кейс менежментэд суурилсан нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор хүргэх, ингэснээр шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг тусгасан;
 - Мэргэжлийн байгууллага ажилтан нь асаргааны хувилбарт үйлчилгээг ахмад настнаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж, байнгын асаргаатай хүн асарч байсан гэр бүлийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй болгох, нийгмийн оролцоог хангах заалтуудыг тусгав.

4. Нийгмийн халамжийн зарим тэтгэмж, дэмжлэгийг амьжиргааны түвшинтэй уялдуулах, хэмжээг эмзэг байдлаас шалтгаалан ялгаатай тогтоох, зарим дэмжлэгийг тодорхой хугацаанд олгон зогсоох, нөхцөл, шалгууртай болгох зэрэг өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд нарийвчлан тусгасан.
5. Одоогийн хуулийн хүрээнд нийгмийн халамжийн олон төрлийн хөтөлбөр хэрэгжиж, хамрах хүрээ өргөн байгаа боловч өрх, иргэний амьжиргааны түвшинтэй, орлогын байдалтай уялдуулсан үйлчилгээ бараг байхгүй байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай амьжиргаа багатай өрх, тэдний хүүхдүүд, хөдөлмөрийн чадваргүй гишүүн, орон гэргүй өрх иргэн зэрэг төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай хэсэгт чиглэсэн халамжийн үйлчилгээг сайжруулах заалтуудыг тусгасан.
6. Асрамжийн газраас гарсан хүүхэд, залуус, гэр оронгүй, архинд донтсон, хорихоос суллагдсан зэрэг нийгмийн зүгээс дэмжлэг шаардлагатай иргэдийг бие даан амьдрахад дэмжих үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан тусгасан.
7. Уур амьсгалын өөрчлөлт, зуд зэрэг байгалийн гамшигт нэрвэгдэж малчид амьжиргааны эх үүсвэрээ алддаг. Иймд гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэн үзүүлэх, энэ чиглэлд халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хүргэх зохицуулалтыг тусгасан.
8. Нийгмийн халамжийн салбарт мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, нийгмийн ажилтны мэргэжлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, нийгмийн ажилтан цаастай биш, зорилтот өрх иргэн, олон нийттэй ажиллах зохицуулалтыг тусгав.
9. Халамжийн үйлчилгээний сонголтын хязгаарлагдмал байдлыг өөрчлөн уян хатан болгож, зорилтот иргэнийг тодорхойлоход гарах хамруулалтын болон орхигдуулалтын алдааг багасгаж, үйлчилгээнд хамрагдах иргэний үйлчилгээ авах шат дамжлагаас чөлөөлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн өөрчлөлтүүдийг тусгасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийг дагалдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд батлагдсанаар нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцооны хамрах хүрээ нь оновчтой, зорилтот бүлэгт чиглэсэн, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байж, үйлчилгээ нь иргэдийн идэвх сонголтод тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдсан, уян хатан, чанартай, хүртээмжтэй болно.

Мөн нийгмийн халамжийн тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээний төрлүүдийг оновчтой тогтоон зарим хөнгөлөлт, тусламжийг нэгтгэн багцлах, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн амьжиргааг сайжруулах, бие даан амьдрахыг дэмжихэд чиглэсэн шинэ үйлчилгээ бий болгох нь ядуурал буурахад эерэг нөлөө үзүүлэх болно.

Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг дагалдуулан нийт 22 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн захиргааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, иргэд, олон нийтээс санал авч, хэлэлцүүлгүүд хийж саналыг тусган боловсруулсан. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 01/1696 дугаар албан бичгийг хүргүүлсэн.

Хуулийн төсөлд санал авахаар Монгол Улсын ерөнхий прокурорын газарт 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 01/990 дугаар албан бичгийг, Монгол Улсын дээд шүүхэд 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” 01/1014 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлсэн боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй тул мөн хуулийн 20.2-т заасны дагуу “тусгайлан өгөх саналгүй” гэж үзсэн болно.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж байгаа нийт зардлыг бууруулахгүйгээр, одоогийн халамжийн төсвийн хүрээнд дахин хуваарилалт хийх зарчим баримтлах тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсгэхгүй, халамжийн зардлын үр ашиг сайжрах юм. Энэ шинэчлэл бол халамжийг танах тухай биш, харин халамжийг зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хүнд, зөв хэлбэрээр, хэрэгтэй үед нь хүргэдэг болгох тухай юм.

---oOo---